



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/54

Мандалговь

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлагуудын 2019 оны
үйл ажиллагааны үр дүнгийн тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, 40.5 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11.1, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн дүнг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр “Санаачлагатай сайн” үнэлгээ авч Тэргүүн байр эзэлсэн “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг “Өргөмжлөл” 1000000 (Нэг сая) төгрөгөөр, хоёрдугаар байр эзэлсэн Онцгой байдлын газрыг “Өргөмжлөл” 800000 (Найман зуун мянган) төгрөгөөр, гуравдугаар байр эзэлсэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг “Өргөмжлөл” 500000 (Таван зуун мянган) төгрөгөөр тус тус шагнасугай.

Гурав. Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Санаачлагатай сайн” үнэлгээ авсан Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад 1 сарын үндсэн цалингийн 80 хувь, эхний 1-3 дугаар байр эзэлсэн хэлтэс, агентлагийн даргаас бусад Санаачлагатай сайн үнэлэгдсэн аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа хэлтэс, агентлагийн дарга болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд 1 сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн сандаа багтаан олгохыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Дөрөв. Хяналт шинжилгээний үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэн ажиллахыг нийт хэлтэс агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

Тав. Шагналд шаардагдах 2540000 (Хоёр сая таван зуун дөчин мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ 482010150

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУЛДЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГУУДЫН 2019 ОНЫ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТЭЛ


 Д. ДУГААР САРЫН ...-НЫ ӨДРИЙН ... ДУГААР
 ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТ



№	Хэлтэс, агентлагийн нэр	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ				Дундаж	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ				Дундаж	Байгууллагын мээлтэй байдлын үнэлгээ				Дундаж	Ерөнхий үнэлгээ
		Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	Яамдын сайдтай Аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт		Аймгийн Засаг даргын 2019 оны 01 захирамжийг хэрэгжүүлэх тухайн байгууллагын	Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт	Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт		Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс үетрэлтийн үнэлгээ	Шударга байдлын түвшний үнэлгээ	Хэрэглэгчийн үнэлгээ		
1	ГХБХБГ	98	100	97	97.6	98.2	99.8	97.3	100	93.9	97.7	97	96	94.0	97.2	96.1	97.32
2	ОБГ	100	100	99	95.7	98.7	95.9	97.4	97.3	91.2	95.5	99	98.3	98.0	91.3	96.7	96.93
3	БОАЖГ	94.7	94	96	98.3	95.8	96.1	96.6	98.6	95.1	96.6	94.5	98.7	98.0	88.3	94.9	95.74
4	УБХ	98	99.5	97	100	98.6	81.6	92.7	100	89.3	90.9	94	98.7	98.0	94.0	96.2	95.24
5	МХГ	-	98	94	100	97.3	85.4	94.7	100	94.8	93.7	93.5	96	97.0	90.8	94.3	95.13
6	ХХҮГ	95	100	93	89	94.3	98.8	94.1	94	94.1	95.2	95	98.7	96.0	88.8	94.6	94.71
7	ЦГ	92.5	100	91.3	95	94.7	92.8	89.9	100	79.1	90.4	94	98.7	92.0	87.2	93.0	92.71
8	СХ	-	99	90.3	-	94.7	84.6	90.5	94.1	89.4	89.6	93	93.3	92.0	89.3	91.9	92.06
9	БСУГ	95	95.7	94.8	95.1	95.2	89.3	95.4	97.2	85.0	91.7	84	85.9	95.6	86.2	87.9	91.60
10	СХЭХ	98	-	92	100	96.7	84.4	93.9	92.2	85.6	89.0	90.5	84.2	90.8	89.6	88.8	91.49
11	НДХ	100	99	87.3	94	95.1	81.5	86.1	100	85.8	88.3	88	97.7	96.0	77.9	89.9	91.11
12	СХАА	-	-	91	100	95.5	84.8	89.4	93	77.5	86.2	90	94.3	90.0	86.1	90.1	90.59
13	УЦУОШТ	-	-	91	-	91.0	94.6	86.9	98.9	85.1	91.4	90	87.6	90.0	85.6	88.3	90.22
14	ЭМГ	85.4	100	80.4	85.9	87.9	77.9	88	98.4	87.6	88.0	87.3	94.3	92.3	86.5	90.1	88.66
15	ХХААГ	84.1	93.5	87	93.2	89.5	86.4	76.2	95.4	83.7	85.4	88	93.6	90.0	89.6	90.3	88.39
16	БТСГ	90	85	88.5	-	87.8	94.7	85	96.2	75.8	87.9	87	93.6	90.0	85.7	89.1	88.27
17	ТХ	90	84.5	90.3	85	87.5	82.5	90.2	95.5	85.0	88.3	90	86.6	92.0	87.0	88.9	88.21
18	ШШЛГ	94	98	87.5	70	87.4	85.6	87.1	100	77.8	87.6	90	95.3	91.0	79.2	88.9	87.95
19	ГБХЗХГ	52	100	86	92.5	82.6	88.8	92.2	98.9	83.0	90.7	88	91.9	90.0	89.4	89.8	87.73
20	ОНӨГ	87	70	90	94	85.3	77.8	86.8	94.1	81.3	85.0	87.5	93.6	90.0	85.2	89.1	86.45
21	ШШДалба	-	70	83.7	-	76.9	79.7	87.2	100	82.1	87.2	85	95.3	90.0	86.2	89.1	84.40
22	МЭГ	80	92.5	90.3	-	87.6	89.6	83.2	92.3	73.0	84.5	80	87.6	50.0	81.5	74.8	82.30
ДҮН		90.2	93.6	90.8	93.3	91.7	87.8	90.0	97.1	85.2	90.0	90.2	93.6	91.0	87.4	90.6	90.8

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС